

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА, ЦАГДААГИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2013 оны 06 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар А-12/158/360

Улаанбаатар  
хот

**Журам батлах тухай**

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Гүйлгээнээс илэрсэн хуурамч, мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах журам”-ыг нэгдүгээр, “Хуурамч мөнгөн тэмдэгтийг санд хүргүүлэх хүснэгт”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг хамтран тооцож ажиллахыг Монголбанкны Мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийн газар /захирал П.Сүхбаатар/, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /дарга Х.Бум-Эрдэнэ/, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газар /дарга, цагдаагийн хурандаа Н.Ууганбаяр/ -т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 452/81/483 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ  
  
Н.ЗОЛЖАРГАЛ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА  
  
Д.БАЯРСАЙХАН

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ  
  
Б.БИЛЭГТ



**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсын нутаг дэвсгэрт бэлэн мөнгөөр гүйлгээ хийж байгаа иргэн, аж ахуйн нэгж, банк, санхүүгийн байгууллагуудын гүйлгээнд хуурамч мөнгөн тэмдэгт оруулахгүй байх, гүйлгээнээс илэрсэн тохиолдолд хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах, харилцан мэдээ, мэдээлэл солилцох болон хуурамч мөнгөн тэмдэгт үйлдэх, ашиглах, борлуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг зохион байгуулахад оршино.
- 1.2. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.
  - 1.2.1. Хуурамч мөнгөн тэмдэгт гэж хуурамчаар үйлдэгдсэн Монгол улсын болон гадаад орны мөнгөн тэмдэгт, зоосыг,
  - 1.2.2. Сан гэж гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газарт нэгтгэн, архивын хууль тогтоомжийн дагуу төрөлжүүлэн, хадгаламжийн нэгж үүсгэснийг тус тус ойлгоно.
- 1.3. Монгол улсын нутаг дэвсгэрт хуурамч мөнгөн тэмдэгт илэрсэн тохиолдол бүрт иргэн, хуулийн этгээд нь нэн даруй цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, гүйлгээнд оруулахгүй байх үүрэгтэй.
- 1.4. Энэ журмыг Монгол улсад оршиж буй иргэн, хуулийн этгээд нийтээр дагаж мөрдөнө.
- 1.5. Энэ журмын хэрэгжилтийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар тус тус зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавина.
- 1.6. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 1.7. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон иргэн, хуулийн этгээд нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай мэдээ мэдээлэл, холбогдох баримт бичгийг цагдаагийн байгууллагад шуурхай гарган өгч, дэмжлэг үзүүлж ажиллана.

**Хоёр. Хуурамч мөнгөн тэмдэгтийг хураах, хүргүүлэх**

- 2.1. Хуурамч мөнгөн тэмдэгт илэрсэн тохиолдолд иргэн эсхүл хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан нь нэн даруй тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх, хуурамч мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийхийг завдсан, хийсэн этгээдийн талаарх мэдээллийг эрх бүхий алба хаагчид мэдээлэх, боломжтой тохиолдолд сэжигтэй этгээдийг саатуулж цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгөх үүрэгтэй.

- 2.2. Банк, санхүүгийн байгууллагын ажилтан нь хуурамч мөнгөн тэмдэгтийг илрүүлсэн тохиолдолд гүйлгээг зогсоож, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэн, холбогдох баримт сэлтийг хүлээлгэж өгнө.
- 2.3. Хуурамч мөнгөн тэмдэгтийг иргэн, хуулийн этгээд хадгалах, хуулийн байгууллагаар шалгуулахаас бусад зорилгоор бусдад шилжүүлэх, дамжуулах, хувилж олшруулах, зөөх, тараах, устгахыг хориглоно.
- 2.4. Хуурамч мөнгөн тэмдэгт илэрсэн тохиолдолд хуулийн этгээд нь хуурамч мөнгөн тэмдэгтийг санд хүргүүлэх хүснэгтийн дагуу 2 хувь хөтөлж, нэг хувийг хуурамч мөнгөн тэмдэгтийн хамт цагдаагийн байгууллагад өгнө.
- 2.5. Мөнгөн тэмдэгтийн хуурамч эсэхийг Монголбанк, Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн тогтооно.

### **Гурав. Хуурамч мөнгөн тэмдэгтийг бүртгэх, шалгах, тайлан гаргах**

- 3.1. Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газар нь хуурамч мөнгөн тэмдэгтийн нэгдсэн сан бүрдүүлж төв, орон нутгийн цагдаагийн байгууллагаас ирүүлсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүлээн авч хадгална. Санд бүртгэгдсэн хуурамч мөнгөн тэмдэгтэд дүн шинжилгээ хийж, улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэргийн гаралт, үйлдлийн аргыг судлан, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх бодлого боловсруулан, гэмт хэргийг шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 3.2. Сан хариуцсан ажилтнууд нь материалын хийц, үйлдлийн аргыг тогтоож улмаар гэмт хэргийг бүрэн дүүрэн илрүүлэх зорилгоор хуурамч мөнгөн дэвсгэртийг криминалистикийн шинжилгээнд хамруулж болно.
- 3.3. Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс нь өөрийн байгууллагад хуурамч мөнгөн тэмдэгтийн талаар ирсэн гомдол, мэдээллийг хүлээн авч шалгахдаа, шалгаж байгаа хуурамч мөнгөн тэмдэгттэй адил аргаар хийгдсэн, адил серитэй мөнгөн тэмдэгт урьд нь бүртгэгдсэн эсэх талаарх лавлагааг нэн даруй нэгдсэн сангаас авна. Гомдол, хэргийг шалгаж шийдвэрлэсний дараа Эрүүгийн цагдаагийн газарт хариу мэдэгдэнэ.
- 3.4. Цагдаагийн байгууллага нь хуурамч мөнгөн тэмдэгтийг илрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр түргэн шуурхай хэргийг шалгаж шийдвэрлэнэ.
- 3.5. Эрүүгийн цагдаагийн газар нь хуурамч мөнгөн тэмдэгтийн нөхцөл байдал, сангийн үйл ажиллагаатай холбоотой тайланг хагас, бүтэн жилээр гаргаж Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх бөгөөд бусад цагт тухайн байгууллагуудаас бичгээр гаргасан хүсэлтийн дагуу нөхцөл байдлын мэдээг гаргаж өгнө. Тайланд тусгагдсан мэдээллийн нууцлалыг тухайн байгууллагууд хариуцна.

### **Дөрөв. Хуурамч мөнгөн тэмдэгтийг хадгалах**

- 4.1. Хуурамч мөнгөн тэмдэгтийг Эрүүгийн цагдаагийн газрын хамгаалалтад байлгана.
- 4.2. Эрүүгийн цагдаагийн газрын тухайн чиглэл хариуцсан ажилтан нь хуурамч мөнгөн тэмдэгтийг илэрсэн хугацаа, үйлдлийн арга, серийн дугаар, дэвсгэртийн хэмжээ, валют тус бүрээр нь ангилж, зориулалтын тусгай хамгаалалттай шүүгээ саванд хадгална.

- 4.3. Санд байгаа хуурамч мөнгөн тэмдэгтүүдийг гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх болон судалгаа, шинжилгээ, сургалт зохион байгуулах зорилгоор ашиглаж болно.
- 4.4. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу санд хадгалагдаж буй хуурамч мөнгөн тэмдэгтийг шилжүүлнэ.

**Тав. Хуурамч мөнгөн тэмдэгтийг устгах**

- 5.1 Цагдаагийн байгууллагаас эрүүгийн хэрэг нь шүүхээр шийдвэрлэгдэж дууссан, хадгалах шаардлагагүй болсон хуурамч мөнгөн тэмдэгтийг устгуулахаар Монголбанкинд хүргүүлнэ.
- 5.2. Монголбанк хуурамч мөнгөн тэмдэгтийг устгахдаа тус банкнаас гаргасан гүйлгээнээс хасагдсан, муудсан мөнгөн тэмдэгтийг устгах ажиллагааны журмын дагуу прокурорын байгууллагын ажилтны хяналтанд эрүүгийн цагдаагийн газрын төлөөллийг оролцуулан акт үйлдэж устгана.

**Зургаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх хамтын ажиллагаа**

- 6.1. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Цагдаагийн байгууллага нь хамтран энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр хамтран ажил зохион байгуулж, сургалтын материал бэлтгэнэ.
- 6.2. Гэмт этгээдүүдээс хуурамч мөнгөн тэмдэгт үйлдэхдээ ашигласан тусгай зориулалтын багаж, төхөөрөмжийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэхэд ашиглуулах зорилгоор эрүүгийн цагдаагийн газарт хэргийг шийдвэрлэж дууссаны дараа шилжүүлж өгнө.
- 6.3. Хуурамч мөнгөн тэмдэгтээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Цагдаагийн байгууллага нь хамтран сургалт зохион байгуулах бөгөөд сургалт, сурталчилгааны холбогдох зардлыг Монголбанк, хуурамч мөнгөн тэмдэгтийг илрүүлэх, шалгах, хадгалахтай холбогдон гарах зардлыг Цагдаагийн байгууллага тус тус хариуцна.

Монгол Банкны Ерөнхийлөгч Санхүүгийн зохицуулах  
 хорооны дарга, Цэгдээгийн ерөнхий газрын даргын  
 2013 оны 1-184/158/160 дугаар хамтарсан  
 тушаалын хоёрдугаар хавсралт

**Хуурамч мөнгөн тэмдэгтийг санд хургүүлэх хүснэгт**

№	Илэрсэн огноо	Хуурамч мөнгөн тэмдэгтийн хэмжих нэгж	Тоо ширхэг	Сери дугаар	Илэрсэн аймаг, хот, сум, дүүрэг, хороо, баг	Холбогдогч этгээдийн нэр, регистрийн дугаар бусад мэдээлэл	Илрүүлсэн байгууллага, ажилтны нэр, утас, регистрийн дугаар	Хүлээлгэн өгсөн хүний нэр, албан тушаал, утасны дугаар, гарын үсэг, огноо	Хүлээн авсан хүний нэр, албан тушаал, утасны дугаар, гарын үсэг, огноо
1.									